



**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ**

2022 оны 11 сарын 16 өдөр

Дугаар 4/164

Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 9 дүгээр зүйлийн 9.6.1, 9.8-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга, хот байгуулалтын яамны чанарын бодлого, зорилтын хэрэгжилт, чанарын удирдлагын тогтолцооны үр дүнд "Удирдлагын дүн шинжилгээ хийх журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Удирдлагын дүн шинжилгээний хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллахыг газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Д.Баярсайхан/-д даалгасугай.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



С.МАГНАЙСҮРЭН

Барилга, хот байгуулалтын яамны Төрийн  
нарийн бичгийн даргын 2022 оны 44-р сарын  
16-ны өдрийн 44/167 дугаар тушаалын хавсралт

## **УДИРДЛАГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ**

### **Нэг. Зорилго**

1.1. Энэхүү журам нь Барилга, хот байгуулалтын яамны чанарын бодлого, зорилго, зорилтын хэрэгжилт, чанарын удирдлагын тогтолцооны үр дүнд удирдлагын зүгээс дүн шинжилгээ хийх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

### **Хоёр. Хамрах хүрээ**

2.1. Барилга, хот байгуулалтын яамны чанарын менежментийн тогтолцоог удирдаж буй удирдлага, чанарын баг, дотоод аудитууд мөрдөн ажиллана.

### **Гурав. Баримт бичгийн хариуцагч**

3.1. Барилга, хот байгуулалтын яамны чанарын баг, дотоод аудитууд хариуцна.

### **Дөрөв. Нэр томьёо, тодорхойлолтууд**

4.1. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр, томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. "Тогтолцоо" гэж харилцан уялдаа буюу харилцан үйлчлэл бүхий багц бүтээгдэхүүн хэсгийг;

4.1.2. "Менежментийн тогтолцоо" гэж бодлого, зорилтуудыг тогтоож, тэдгээрт хүрэх тогтолцоог;

4.1.3. "Чанарын менежментийн тогтолцоо" гэж байгууллагын чанарын талаар удирдан чиглүүлэх, хянах удирдлагын тогтолцоог;

4.1.4. "Удирдлага" гэж байгууллагыг удирдан чиглүүлэх, хяналтыг зохицуулсан үйл ажиллагааг;

4.1.5. "Чанарын бодлого" гэж дээд удирдлагаас албан ёсоор илэрхийлсэн чанарт хамаарах байгууллагын нийт зорилго ба чиглэлийг;

4.1.6. "Чанарын зорилт" гэж чанарын удирдлагын тогтолцооны талаар буюу хүрэхээр зорьж, эрмэлзсэн зүйлийг;

4.1.7. "Дүн шинжилгээ" гэж объект нь тогтоосон зорилтод хүрэхэд хир тохиромжтой, хангалттай бөгөөд үр нөлөөтэй болохыг тодорхойлохын тулд хэрэгжүүлэх үйл ажиллагааг.

### **Тав. Удирдлагын дүн шинжилгээний оролт**

5.1. Удирдлагын дүн шинжилгээг Барилга, хот байгуулалтын яамны зорилго, зорилт, стратеги төлөвлөгөө нь чанарын менежментийн тогтолцоотой нийцэж буй эсэх болон үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлохын тулд хийнэ.

5.2. Удирдлагын дүн шинжилгээг чанарын менежментийн тогтолцоог удирдаж буй удирдлага хийнэ.

5.3. Удирдлагын дүн шинжилгээний оролт болгон цуглуулсан мэдээлэл, өгөгдөл, баримт бичигт дүгнэлт хийх замаар удирдлагын дүн шинжилгээг явуулна.

5.4. Удирдлагын дүн шинжилгээний оролтод дараах баримт бичиг, мэдээллийг ашиглана. Үүнд:

- Чанарын гадаад болон дотоод аудитын үр дүн;
- Үйлчлүүлэгчдээс ирсэн гомдол, санал хүсэлт, бусад мэдээлэл;
- Сэргийлэх болон залруулах арга хэмжээ авсан байдал;
- Өмнөх жилийн удирдлагын дүн шинжилгээний мөрөөр авсан арга хэмжээ;
- Чанарын менежментийн тогтолцоонд нөлөөлж болохуйц техник, технологи зохион байгуулалт, боловсон хүчин зэрэг томоохон өөрчлөлтүүд;
- Төрийн болон төрийн бус байгууллагаас чанарын менежментийн тогтолцооны хэрэгжилтийг сайжруулах талаар өгсөн зөвлөмж;
- Ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах болон боловсон хүчний мэдлэгийг дээшлүүлэх талаар авсан арга хэмжээ;
- Холбогдох хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлт, үйл ажиллагаанд нөлөөлж болох бусад хүчин зүйл.

### **Зургаа. Удирдлагын дүн шинжилгээний гаралтууд**

6.1. Удирдлагын дүн шинжилгээний гаралт нь дараах зүйлд хамаарах шийдвэр, арга хэмжээг багтаана. Үүнд:

- Чанарын менежментийн тогтолцоо болон түүний үйл явцуудын үр нөлөөг сайжруулах;
- Хэрэглэгчийн шаардлагад нийцэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөц.

6.2. Чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх чанарын багийн ахлагч нь “Удирдлагын дүн шинжилгээний тайлан”-г энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу гаргаж Барилга, хот байгуулалтын яамны газар, хэлтсийн дарга нар болон чанарын багийг оролцуулан өргөтгөсөн хурлаар хэлэлцүүлнэ.

6.3. Чанарын менежментийн тогтолцоог удирдаж буй удирдлага тайланг хэлэлцэж дууссаны дараа журмын 2 дугаар хавсралтын дагуу тушаалын төсөл, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.

6.4. Чанарын багийн ахлагч нь хуралдааны тэмдэглэл, хуралдааны хөтөлбөр зэрэг баримтжуулсан мэдээллийг байнга хөтлөх ба Удирдлагын дүн шинжилгээний хурлаас гарсан шийдвэрийг холбогдох албан хаагчдад мэдээлнэ.

## УДИРДЛАГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

№	Удирдлагын дүн шинжилгээний үзүүлэлтүүд	..... он	..... он	Тэмдэглэл
1.	Чанарын гадаад болон дотоод аудитын үр дүн			
2.	Дотоод аудитын үр дүнд хийсэн залруулах арга хэмжээ			
3.	Дотоод аудитын үр дүнд хийсэн Сэргийлэх арга хэмжээ			
4.	Үйлчлүүлэгчдээс ирсэн санал хүсэлт, өргөдөл гомдол			
5.	Өмнөх удирдлагын дүн шинжилгээний мөрөөр авсан арга хэмжээ			
6.	Чанарын менежментийн тогтолцоонд нөлөөлж болохуйц өөрчлөлт			
7.	Төрийн болон төрийн бус байгууллагаас чанарын менежментийн тогтолцооны хэрэгжилтийг сайжруулах талаар өгсөн зөвлөмж			
8.	Ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах болон боловсон хүчний мэдлэгийг дээшлүүлэх талаар авсан арга хэмжээ			
9.	Чанарын менежментийн тогтолцооны баримт бичгүүдийг боловсронгуй болгох талаар авсан арга хэмжээ			

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ТУШААЛ

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 9 дүгээр зүйлийн 9.6.1, 9.8-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. .... оны удирдлагын дүн шинжилгээний тайланг ..... зөвшөөрсүгэй.

2. Барилга, хот байгуулалтын яамны чанарын менежментийн тогтолцооны гүйцэтгэлийг сайжруулах, сонирхогч талуудын сэтгэл ханамжийг дээшлүүлэх чиглэлээр авах арга хэмжээний ... оны төлөвлөгөө, шаардагдах зардлыг 1 дүгээр хавсралтаар, Чанарын менежментийн тогтолцооны баримт бичгийг хөгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг газар, хэлтсийн дарга нарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг чанарын багийн ахлагч /...../-т тус тус үүрэг болгосугай.

..... ДАРГА

/...../

гарын үсэг

1 дүгээр хавсралт

Чанарын менежментийн тогтолцооны хэрэгжилт, гүйцэтгэлийг сайжруулах, сонирхогч талуудын сэтгэл ханамжийг дээшлүүлэх чиглэлээр авах арга хэмжээний ... оны төлөвлөгөө, шаардагдах зардлын төсөв

№	Авах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах албан тушаалтан	Зардал /мян.төг/
1.	.....	.....	.....	.....

2 дугаар хавсралт

Чанарын менежментийн тогтолцооны баримт бичгийг хөгжүүлэх ажлын төлөвлөгөө

№	Баримт бичгийн нэр	Боловсруулагч	Шийдвэрлүүлэх хугацаа /сараар/
1.	Шинээр боловсруулах баримт бичиг		
2.	Дахин хянаж шинэчлэн сайжруулах баримт бичиг		
3.	Магадлан шалгах баримт бичиг		